



## **“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК**

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4-р хүрээ Цэцэгүн 206 тоот  
Утас: (+976) 990965848 (+976) 70001981  
И-мэйл: csi\_sevjee@yahoo.com

2022.04.20 № 23/170

“Гермес центр” ХК-ийн  
Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг  
танаа

Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### **Хараат бус аудиторын тайлан**

#### **Дүгнэлт:**

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу “Гермес центр” ХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд гэрээний дагуу аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Гермес центр” ХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл:**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

#### **Аудитын гол асуудлууд:**

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна

#### **Бусад мэдээлэл:**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланда орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланда гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

#### Санхүүгийн тайланда удирдлагын хүлээх хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм. Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохиорох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.

#### Аудиторын хүлээх хариуцлага:

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит батапгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтээр өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэж итгэж байгаач АОУС-ын дагуу хийж гүйцэтгэж байгаа аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш.

#### Бусад:

Энэхүү тайланг компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын эмне ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн:



Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо 111 тоот  
Утас: 976-70001981, 99096584  
И-мэйл: csi\_sevjee@yahoo.com